



БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН
ХӨГЖЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОГЧ

ЗӨВШӨӨРСӨН,
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОР БӨГӨӨД
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГАЗРЫН ДАРГА


П.БАЯРХҮҮ


Э.АНАР

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 24 ДҮГЭЭР ХОРОО, БАРУУН САЛААНЫ ЗАМААС
ЗҮҮН ЗҮГТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ СУРГУУЛЬ
ХҮРТЭЛ ШИНЭЭР БАРИГДАХ АВТО ЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар 3Д-14/44

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэл, дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл
2. Байршил	Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр
4. Замын техникийн ангилал, замын зэрэг	Туслах гудамж зам-Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5. Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6. Замын хучилтын хийц	Боловсронгуй төрлийн хучилттай. Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ.
7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2017 он
8. Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9. Захиалагч байгууллага	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
10. Зураг төслийн иж бүрдэл	1. Геодезийн ажлын тайлан 2. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан 3. Холбогдох техникийн нөхцлүүд 4. Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл 5. Зургийн тайлбар бичиг 6. Техникийн шаардлага 7. Ажлын нэр төрөл, тоо хэмжээ 8. Барилгын ажлын төсөв
11. Онцгой нөхцөл:	<p>➤ Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, "Авто зам төсөллөх" БНБД 32.01.07, "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын</p>

төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Зам замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар” 33БНБД81-013-2016, “Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм” 33БНБД83-017-2016, ЗГ-ын 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрэм” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх

- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барих үед геометр хэмжээг хангах хэмжилтийн төсөл-даалгавар боловсруулах. Геодезийн хяналтын инженерээр хянуулж баталгаажуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 оны хөгжлийн чиг хандлага, одоо байгаа болон шинээр төлөвлөгдөж буй авто замын зураг төслийн трасстай уялдуулан зураг төслийг боловсруулах
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох.
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, автомашин, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах
- Авто замын трасд орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах.
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын Хөдөлгөөний Удирдлагын төвтэй зөвшилцөх
- Авто зам, зогсоолын гадаргуун ус зайлуулах байгууламжийг орчноор нь тооцох
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК руу бие даан


хандаж /эргэдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах. Одоо байгаа гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх зэрэг холбогдох асуудлуудыг мөн шийдвэрлэсэн байх

- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:


Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000
	босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтэц	1:20
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга, бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө
- Эскизийн шатанд НАЗХГ, НХТЕТГ, НГА-тай тус тус зөвшилцөх

Хянасан:

Нийслэлийн авто замын хөгжлийн газрын дарга


 /Ж.Тогтохбаяр/

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга

 /Ж.Даваасүрэн/


НХТЕТГ-ын Хот төлөвлөлтийн

хэлтсийн дарга

 /С.Даланжаргал/


НХТЕТГ-ын Инженерийн дэд бүтцийн

төлөвлөлтийн хэлтсийн дарга

 /Б.Оюунтуяа/ ✓


НХТЕТГ-ын Хот төлөвлөлтийн

хэлтсийн архитектор

 /П.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

 /Н.Энхтуяа/

2017 оны 08 сарын 28 өдөр




НИЙСЛЭЛИЙН АВТО
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Map
a description for your map

Газрын байршил
Сонгинохайрхан дүүрэг, 24-р
хороо

Газрын зориулалт
Авто зам

- Legend
- Unlabeled
 - Unlabeled
 - Feature
 - Patch
 - Patch
 - Path Me



Таних тэмдэг



Шинээр хийх авто зам


Хянасан:
НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга.....*Р*...*Ж.Даваасүрэн*

Боловсруулсан:
НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн.....*М*...*Н.Энхтуяа*

БАРИЛГАЖИХ ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Сонгинохайрхан дүүргийн 24-р хороо	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар	Авто зам



Масштаб 1: 5,000

Тусгааг : WGS 1984 UTM Zone 48N

(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)


ТАНИХ ТЭМДЭГ

- Одоо байгаа барилга
- Төлөвлөж байгаа барилга
- Газрын хэмжээ
- Цэвэр усны шугам
- Бохирын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Үерийн шугам

ТОДОРХОЙЛОЛТ

Төлөвлөж буй байршил нь СХД-ийн 24-р хороонд Баруунсалааны замаас зүүн зүгт. Барилгажих талбайн схем зургийг авто замын улаан шугам хүртэлх зай хэмжээгээр тоосон. Ажлын зургийн шатанд өөрчлөлт оруулах боломжтой.

БАЙРШЛЫН СХЕМ



Байршлын дугаар : 145221

Эдгэлбэр газар (м2)	XXX
Авто замын урт (км)	0.93

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

Нийслэлийн Засаг захиргааны 2-р байр 1101 тоот
Утас: 11-324975, website: <http://mpa.ub.gov.mn>

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨХ ДААЛГАВАР

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар: ГБМЗХ2020/06-015

Улаанбаатар хот


1	Авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр	Нийслэлийн Авто Зам Хөгжлийн Газрын 2020 оны 01-р сарын 29-ны өдрийн 2/182 дугаартай албан тоотыг үндэслэв.
2	Эзэмшигчийн нэр, авто замын чиглэлийн нэр	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар. /СХД, 24-р хороо, Хустайн 1-р гудамж дагуу Зээл 24-р гудамжны 107 тоот хашаа хүртэлх авто зам/
3	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, гудамж замын сүлжээний төлөвлөлт	"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" "Улаанбаатар хотын төлөвлөлтийн баруун хойд бүсийн Толгойт нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"
4	Авто зам Замын байгууламжийн ангилал, зэрэглэл	Нийслэлийн авто зам Нутаг дэвсгэрийн зам, Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5	Хийц, бүтээц	Бүтээц, хийцлэлийг төслөөр сонгох.
6	Авто замын бүрэлдэхүүн:	Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийг хангах.
	- Авто замын зурвас газар	Авто замын зурвас газрын өргөнийг норм стандартад нийцүүлэн тооцох. Барилгажилт хүртэлх шугамыг нормын дагуу тооцож зураг төсөлд тусгах.
	- Зорчих хэсэг	Авто замын зорчих хэсэг 2 эгнээтэй байх. Замын нэг зурвасын өргөн 3.0 метр
	- Замын байгууламж	Тээврийн хэрэгслийн зогсоол, ус зайлуулах суваг, ногоон зурвас, явган хүний зам, унадаг дугуйн зам, гудамжны гэрэлтүүлэг төлөвлөх.
7	Замын байгууламж:	Замын байгууламжийг норм, стандартад нийцүүлэн иж бүрэн төлөвлөх.
	- Гүүр, нүхэн гарц	Тээврийн хэрэгсэл, явган хүн, унадаг дугуйтай хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн чөлөөтэй зорчих боломжтой байдлаар гүүрэн гарц төлөвлөх.
	- Унадаг дугуй, явган хүний зам	Явган хүн болон унадаг дугуйтай зорчигч зорчих замыг хөдөлгөөний эрчимтэй уялдуулан тооцож төлөвлөх. Унадаг дугуйтай зорчигч зорчих хэсгийг 1.5м-ээс багагүй өргөнтэй төлөвлөх, хэвтээ босоо тэмдэглэгээг стандартын дагуу хийх.
	- Бусад	Ногоон байгууламж, гудамжны гэрэлтүүлгийн шийдлийг тухайн орчны архитектур, гоо зүйтэй уялдуулж төлөвлөх. Гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг сонгон төлөвлөх.
8	Архитектур төлөвлөлтийн шаардлага	Гудамж, замыг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөний эрчимжилт, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, барилга байгууламжийн байршил, архитектуртай нь уялдуулан тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байхаар төлөвлөх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээг тусгах буюу MNS 6056:2009 стандартыг мөрдлөг болгох.
9	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	Авто замын төлөвлөлт нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан, иргэд богино хугацаанд тохь тухтай зорчих шаардлагад нийцсэн байх. Төлөвлөлтийн талбайд өртсөн газар, барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нарийвчлан судалж зураг төсөлд тусгах, Нийслэлийн газрын асуудал хариуцсан байгууллагатай зөвшилцөж төлөвлөлтийн шийдэл гаргах. Нийслэлийн Авто зам, Газрын асуудал эрхэлсэн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр трассын байгуулалт, загвар зураг батлуулах. Ажлын зургийг

		инженерийн шугам сүлжээний хариуцсан байгууллагуудтай зөвшилцөж магадлал хийлгэн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх. Бий болсон өмч хөрөнгийг зөвхөн нийтийн хэрэгцээнд ашиглах.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага	Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгажилт, газрын хэвгийтэй уялдуулж хамрах талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх.
11	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага	Трассын дагуу газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээ, хийгдэхээр төлөвлөж буй шугам сүлжээний төлөвлөлтийг тодруулсны үндсэн дээр зураг төсөл боловсруулах. Шугам сүлжээтэй огтлолцуулах, шилжүүлэх асуудлыг инженерийн шугам сүлжээний хариуцсан байгууллагаас олгосон техникийн нөхцөлийг үндэслэн шийдвэрлэх.
12	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	Хөрсний нүүлт, гулсалтаас хамгаалах арга хэмжээг тухайн газрын геологи-гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн судалсны үндсэн дээр авна.
13	Барилгажилтын улаан шугам	Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу 0 тэнхлэг тавиулж барилгын ажлыг эхлүүлэх.
14	Захиалагчийн нэр, хаяг, утас	НАЗХГ. Утас:325385

Анхааруулга:

1. Зам, замын байгууламжийг барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
2. Төвөгшилтэй зам, замын байгууламжид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
3. Зөвшилцсон трасс болон ажлын зургийг цахим хэлбэрээр Хот байгуулалтын мэдээллийн менежментийн нэгдсэн санд хүлээлгэн өгөх.
4. Зам, замын байгууламжийн шинэчлэх, засварлах шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг даалгаварт хавсаргах.
5. Зам, замын байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, байршил, замын зэрэглэлийг зөрсөн тохиолдолд зам, замын байгууламжийн трассыг зөвшилцөхгүй болно.


Хянасан: Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга С.ДАЛАНЖАРГАЛ
 Боловсруулсан: Хот төлөвлөлтийн хэлтсийн архитектор /Б.ЖАВХЛАНТӨГС/



ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(дугаар: ГБМЗХ2020/06-015 авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Сонгинохайрхан дүүргийн 24-р хороо	НАЗХГ	Авто зам, замын байгууламж



Масштаб 1: 4,000

Тусгаг : WGS 1984 UTM Zone 48N

(Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврын хөмт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

- ДУУССАН БАРИЛГА /Хаяг дугаартай/
- ДУТУУ БАРИЛГА /Хаяг дугаартай/
- ОДОО БАЙГАА БАРИЛГА /Хаяг дугааргүй/
- БАРИЛГА /Төлөвлөгдсөн/
- ДЭД БҮТЭЦ /Төлөвлөгдсөн/
- АВТО ЗАМ /Төлөвлөгдсөн/
- ТОХИЖИЛТ /Төлөвлөгдсөн/
- Газрын хэмжээ
- Дулааны шугам
- Цэвэр усны шугам
- Бохир усны шугам
- Холбооны шугам
- Үерийн ус сайлуулах шугам

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй байршил
2	Төлөвлөсөн барилга
3	Төлөвлөсөн барилга

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	X	Y	тал=урт(м)
1	634747.102	5316065.868	1-2=36.00
2	634745.473	5316101.831	2-3=126.29
3	634871.632	5316107.544	3-4=266.97
4	635130.253	5316173.785	4-5=36.00
5	635139.185	5316138.910	5-6=270.68
6	634876.969	5316071.748	6-1=130.00

ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зурвас газар (м2)	14290.89
Авто замын урт (км)	0.41
Байршлын дугаар:	594974



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
Хот төлөвлөлтийн хэлтэс

Нийслэлийн Засаг захиргааны 2-р байр 1101 тоот
Утас: 11-324975, website: <http://mpa.ub.gov.mn>

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ,
БАРЬЖ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ

1. Зөвшөөрөл
олгох

- Хүсэлт гаргах /нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд/
- Үндэслэл бүхий хариуг ажлын 7 хоногт багтаан албан бичгээр хүргүүлэх
- Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх
- Хурлын шийдвэрийн дагуу зураг төсөл зохиох даалгавар боловсруулж Ерөнхий архитектороор батлуулна
- Батлагдсан зураг төсөл зохиох даалгаварыг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан хүсэлт гаргагчид өгнө

2. Зураг төсөл
зохиох

- Тухайн байгууламжийн зураг төслийг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага загвар зураг төслийг зохионо
- Загвар зургийг батлуулах хүсэлт Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХТЕТГазарт гаргана
- Холбогдох инженерийн шугам сүлжээний байгууллагуудаас техникийн нөхцөл авна
- Ажлын зураг төслийг боловсруулж холбогдох байгууллагуудтай зөвшилцөх
- Ажлын зураг төсөлд магадлал хийлгэх

3. Барилга
угсралтын ажил

- Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн акт хийлгэж хот байгуулалтын мэдээллийн санд бүртгүүлнэ
- Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх хүсэлтийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХТЕТГазарт гаргах
- Олгогдсон зөвшөөрлийн хүрээнд барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх
- Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХТЕТГазарт гаргах
- Барилга, байгууламжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛҮҮДИЙН
УДИРДАГЧ

ЗӨВШӨӨРСӨН:
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОТГОНСҮХ

Б.ИНДРА

АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: ЗД2020/041

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	-Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг -Улаанбаатар хотын төлөвлөлтийн баруун хойд бүсийн Толгойт нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө -Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний XIII.1.1.55-р заалт -Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны 01 сарын 10-ны 03/114 албан тоот -Нийслэлийн хот байгуулалт, Хөгжлийн газрын 2020 оны 02 сарын 18-ны өдрийн ГБМЗХ2020/06-015 дугаартай Авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар
2	Байршил	Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам /УБ, Сонгинохайрхан, 24 дүгээр хороо, Хустайн 1-р гудамж дагуу Зээл 24-р гудамжны 107 тоот хашаа хүртэлх авто зам/
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгөөр
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Нутаг дэвсгэрийн зам
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6	Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2020 он
8	Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9	Захиалагч байгууллага	Зам, тээврийн хөгжлийн яам Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Инженер геологийн судалгааны ажлын тайлан 3. Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл 4. Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто замын зураг төслийн бүрдэл,

холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт)

5. Техникийн шаардлага

6. Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016, “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх. Геодезийн хяналтын инженерээр байр зүйн зураглалыг зураг төслийн төлөвлөлтийн шатанд хянуулж баталгаажуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын төлөвлөлтийн баруун хойд бүсийн Толгойт нэгж хорооллын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хороолол доторх шинээр болон өргөтгөл шинэчлэлт хийгдэж байгаа авто замын зураг төслийн трасстай уялдуулан зураг төслийг боловсруулах
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх. Геодези Усны Барилга Байгууламж ОНӨААТҮГ-тай зураг төслийг зөвшилцөх
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, автомашин, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх

- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын Хөдөлгөөний Удирдлагын төвтэй зөвшилцөх
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийг UTM системд хийх
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах. Одоо байгаа гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх зэрэг холбогдох асуудлуудыг мөн шийдвэрлэсэн байх
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан “LED” технологиор шийдвэрлэх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000
	босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтэц	1:20
- Нийслэлийн Хот байгуулалт, Хөгжлийн газрын Авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар, НАЗХГ-ын Авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах
- Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, ЗХУТ-тэй тус тус зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.
- Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, гүүр, хоолой, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээ, инженерийн шугам сүлжээ, ус зайлуулах байгууламж гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.


Хянасан:

НАЗХГ-ын орлогч даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



/Д.Төрбилэг/


НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



/О.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн
авто замын мэргэжилтэн



/Н.Энхтуяа/

2020 оны 02 сарын 21-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил


Газрын зориулалт


СХД, 24 дүгээр хороо


Авто зам, замын байгууламж



Таних тэмдэг

 Төлөвлөж буй авто зам, замын байгууламж

 УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ЕТ-ний тодотгол,
2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага

 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто зам

Хянасан:

НАЗХГ-ын Бодлого Зохицуулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



/О.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ын БЗХ-ийн авто замын мэргэжилтэн



/Н.Энхтуяа/

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ

Б.ОТГОНСҮХ

ЗӨВШӨӨРСӨН:
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ИНДРА

ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: 32/2020/044

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">Засгийн газрын 2020 оны 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтХот байгуулалт, Хөгжлийн газрын 2020 оны 02 сарын 18-ний өдрийн ГБМЗХ2020/05-013 дугаартай Авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар
2	Байршил	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо, Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг сургуулийн цогцолбор хүртэлх авто зам дахь жалга дээр баригдах гүүр
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Нутаг дэвсгэрийн зам, Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6	Гүүрийн бүтээц	Тооцоог үндэслэнэ. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын техникийн нөхцлийг хангаж, автомашин, явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг хангах зорилгоор барих.
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2020 он
8	Зураг төслийн байгууллага	Авто зам, гүүрийн зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9	Захиалагч байгууллага	Зам тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	<ol style="list-style-type: none">Гүүрийн ажлын зурагИнженер геологийн дүгнэлтГеодезийн ажлын иж бүрэн тайланИнженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлгийн ажлын зурагТехникийн шаардлагаТайлбар бичиг

		<ul style="list-style-type: none"> • Төсөллөж буй гүүрийн танилцуулга, техникийн тодорхойлолт, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх аливаа хүчин зүйлсийн талаархи мэдээ • Бат бэхийн болон буурь, суурийн тооцоо • Тухайн байршил орчмын байгаль цаг уурын статистик мэдээ, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх аливаа байгаль цаг уурын хүчин зүйлсийн тухай мэдээ
		<ul style="list-style-type: none"> • Барилгын ажлын тоо хэмжээ /иж бүрнээр/ • Холбогдох техникийн нөхцөл, холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн албан бичиг, холбогдох материал хавсаргах/ <p>7. Нэгдсэн төсөв / хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм үнэлгээний дагуу боловсруулна/</p>

Онцгой нөхцөл:

- Гүүрийн зураг төслийг Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам, “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016, “Ачаалал ба үйлчлэл /БНБД 2.01.07-90/”, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх /БНБД 22-01-01/”, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/”, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-12, ”Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056 : 2009/” болон бусад холбогдох норм дүрмүүдийг үндэслэнэ.
- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Авто замын мастер төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, НХБХГ, НГЗБА, НАЗХГ-тай үе шаттайгаар санал солилцох, зөвшилцөх
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, ”Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах.
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд УТМ системд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглал хийж, зураг төслийн шатанд геодезийн хяналт хийлгэх, ажлын иж бүрэн тайланг зураг төслийн шатанд хянуулж хүлээлгэн өгөх
- Гүүр баригдах газрын цаг уурын нөхцөл, ус зүйн судалгаа, инженер геологи геотехникийн үзүүлэлтүүдийг тулгуур байрлах хэсэгт нарийвчлан гаргаж тайлан боловсруулах, дээрх үзүүлэлтүүдийг үндэслэн тулгуурийн байрлал, буурь суурийн төрөл, хийцийг бат бэхийн тооцоогоор оновчтой тодорхойлон сонгох.

- Гүүрийн загвар, хийцийг хүрээлэн буй орчинтой зохицуулж өнгө үзэмж сайтай, архитектурын шинэ шийдлээр төлөвлөн гүүрийн загвар зургийг НХБХГ, НАЗХГ-тай зөвшилцөх
- Гадаргуун ус зайлуулалтыг тухайн зам, гүүрийн хэсэг орсон ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх.
- Зургийн ажлын явцад инженерийн шугам сүлжээний байгууллагуудын тодруулга, техникийн нөхцлийг авч, шугам сүлжээний ажлын зураг боловсруулах, магадлалаар батлуулах, бусад холбогдох байгууллагуудтай зөвшилцөх.
- Инженерийн шугам сүлжээг аюулгүй дамжуулах боломж бүрдүүлэх, сувагчлалын гарцыг төлөвлөх, зураг төсөл болон төсөвт тусгах
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Гүүрийн дөхөх болон зорчих хэсгийн үзэгдэх орчин, аюулгүй байдалд үндэслэн гэрэлтүүлгийг оновчтой төлөвлөх.
- Гэрэлтүүлгийн загварыг гүүрийн архитектурын шийдэлд уялдуулан шинэлэг байдлаар төлөвлөх
- Авто зам, гүүрийн үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх.
- Цементбетоны хүйтэн тэсвэрлэлтийг Монгол орны цаг уурын нөхцөлд тохируулах.
- Гэрэлтүүлгийн төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг заалгах/ ажлын зургийг боловсруулах.
- Гүүрийн зураг төслийг холбогдох авто замуудтай уялдуулан иж бүрнээр боловсруулах.
- Зураг төслийг дараахь масштабтайгаар боловсруулна. Үүнд:


- Дэвсгэр зураг	1:500
- Дагуу огтлол	хэвтээ 1:2000
	босоо 1:200
- Хөндлөн огтлол	1:100
- Уулзвар, огтлолцол	1:500
- Бүтээц	1:20
- Хэсэглэл	1:10

• НХБХГ-ын авто-зам, замын байгууламж төлөвлөх даалгаварыг мөн баримтлан зураг төслийг боловсруулах


- Гүүрийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг иж бүрдлээр боловсруулан магадлалаар батлуулан эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ акт үйлдэн хүлээлгэж өгнө.

Хянасан:

НАЗХГ-ын орлогч даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч


 /Д.Төрбилэг/

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

 /Б.Анхбаяр/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн
гүүрийн төлөвлөлтийн мэргэжилтэн

 /М.Ичинхорлоо/

2020 оны 02 сарын 28




НИЙСЛЭЛИЙН АВТО
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил

Газрын зориулалт

Сонгинохайрхан дүүрэг, 24-р
хороо

Гүүр



ШИНЭЭР БАРИГДАХ ГҮҮР

Таних тэмдэг



Шинээр барихаар төлөвлөж буй гүүр

Хянасан:
НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн
Боловсруулсан:
НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

...../Б.Анхбаяр/
...../М.Ичинхорлоо/

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ИНДРА

**СХД, 24 ДҮГЭЭР ХОРОО, БАЯНХОШУУНЫ БАРУУН САЛААНЫ АВТО
ЗАМААС ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ЦОГЦОЛБОР ХҮРТЭЛХ
АВТО ЗАМ, ГҮҮРИЙН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий зүйл	<p>Объектын нэр: Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо, Баянхошууны баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам, гүүр</p> <p>Зураг төслийн иж бүрдэл:</p> <ul style="list-style-type: none">• Авто зам, гүүрийн ажлын зураг• Тайлбар бичиг• Техникийн шаардлага• Геодезийн тайлан• Геологийн тайлан• Инженерийн шугам сүлжээний зураг• Төсөв /Авто зам, гүүрийн инженерийн шугам сүлжээ/
	Гудамж замын ангилал: Нутаг дэвсгэрийн зам
2. Барилгын талбай /замын зурвас/-н үзүүлэлт	Одоо байгаа авто зам нь шороон зам бөгөөд шинээр хатуу хучилттай авто зам барина.
3. Ажлын цар хүрээ	<p>1) Зураг төслийг боловсруулахдаа Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар, Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаварыг үндэслэх</p> <p>2) Инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулах</p> <p>3) Авто зам, замын байгууламжийн зураг төслийг холбогдох газруудтай зөвшилцөн магадлалын дүгнэлт гаргуулах</p>

<p>4. Ажлын хил хязгаар</p>	<p>Төслийн зам нь Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо, Хустайн 1-р гудамж дагуу Зээл 24-р гудамжны 107 тоот хашаа хүртэл /Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар, Авто замын зураг төсөл боловсруулах даалгавараас байршлын зургийг үзэх/</p>
<p>5. Барилгын ажлын зохион байгуулалт</p>	<p>1) Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ г.м/ -ыг бүрэн хангаж ажиллана.</p> <p>2) Гүйцэтгэгч байгууллага Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын даргын 2016 оны А/42 тоот тушаалаар батлагдсан <u>“Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага” ыг засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх хугацаанд чанд мөрдөн ажиллана.</u> Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас холбогдох БНБД-үүд, техник технологийн стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.</p> <p>3) Тухайн засвар шинэчлэлтийн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмийн хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр</p>

	<p>баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>4) Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Авто замын ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна.</p>
6. Бусад	Шинэчлэлт хийгдэх авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

Хянасан:

НАЗХГ-ын орлогч даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч


НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Боловсруулсан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын

Бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн



Д.Төрбилэг



О.Энхбаатар



Н.Энхтуяа

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай
машин механизмууд

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	х/н.	Тоо	Тайлбар
Авто зам барих ажил				
1	Автогрейдер /250м.х-с дээш/	шр	1	Өөрийн болон түрээс
2	Автокран /8тн/	шр	1	Өөрийн болон түрээс
3	Усны машин /5тн-оос дээш/	шр	1	өөрийн
4	Индүү /доргиурт 10тн-оос дээш/	шр	1	Өөрийн болон түрээс
5	Индүү /доргиурт 10тн-оос доош/	шр	1	Өөрийн болон түрээс
6	Доргиурт индүү /20тн-оос дээш АБ/	шр	1	Өөрийн болон түрээс
7	Хийн дугуйт индүү /20тн АБ/	шр	1	Өөрийн болон түрээс
8	Гар индүү	шр	1	өөрийн
9	Асфальтбетон дэвсэгч /7.0 б-ээс багагүй/	шр	1	Өөрийн болон түрээс
10	Автогудронатор /3.5м/	шр	1	Өөрийн болон түрээс
11	Асфальтобетон завод /80 тн/цаг/	шр	1	түрээс
12	Асфальт бетон зүсэгч хөрөө /2 м/мин/	шр	1	өөрийн
13	Бетон зуурагч /гагнууртай/	шр	1	өөрийн
14	Компрессор /7м3/	шр	1	өөрийн
15	Лаборатори /иж бүрэн/	шр	1	Өөрийн болон түрээс
Гүүр барих ажил				
1	Эксковатор /0.65м.куб/	шр	1	өөрийн
2	Авто ачигч /1.5-3.0м.куб/	шр	1	түрээс
3	Гар индүү	шр	1	өөрийн
4	Авто кран /25тн-оос дээш/	шр	1	өөрийн
5	Авто кран /50тн-оос дээш/	шр	1	Өөрийн болон түрээс
6	Автосамосвал /6м.кубээс дээш/	шр	5	өөрийн
7	Бага оврын ачааны машин /3-5тн/	шр	1	Өөрийн болон түрээс
8	Том оврын ачааны машин /10-15тн/	шр	2	Өөрийн болон түрээс
9	Арматур таслагч, нугалагч	шр	1	өөрийн
10	Өргөгч тавцан	шр	1	Өөрийн болон түрээс
11	Гүний вибратор	шр	2	өөрийн
12	Талбайн вибратор	шр	1	өөрийн
13	Гагнуурын аппарат	шр	2	өөрийн
14	Геодезийн багаж /иж бүрэн/	шр	1	өөрийн
15	Зөөврийн цахилгаан үүсгүүр	шр	1	өөрийн

16	Талбайн зөөврийн гэрэл	шр	1	Өөрийн болон түрээс
17	Гэрэл ойлгогч зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа	Иж бүрдэл	2	өөрийн
18	Автомат нивилер	шр	1	өөрийн
19	Электрон теодолит	шр	1	өөрийн
20	Зурган баримтжуулалт гүйцэтгэхэд шаардагдах рейк, метр, гадас, самбар	Иж бүрдэл	1	өөрийн
21	Цахилгаан гар хөрөө	шр	1	өөрийн
22	Цахилгаан гар ором	шр	1	өөрийн

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан

№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага /жил/
1	Гүүр барилгын инженер /Ерөнхий инженер/	1	5 болон түүнээс дээш
2	Гүүр барилгын инженер /инженер/	1	3 болон түүнээс дээш
3	Авто замын барилгын инженер	2	3 болон түүнээс дээш
4	Геодезийн инженер	1	2 болон түүнээс дээш
5	Хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн	1	3 болон түүнээс дээш

Хянасан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын


Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Д.Төрбилэг

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын

Зам барилгын хяналтын хэлтсийн дарга



Б.Бум-Эрдэнэ

Боловсруулсан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын

ЗБХХ-ийн гүүрийн хяналтын мэргэжилтэн:



Я.Өнөртүвшин